






**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2015 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2015.11.11

№	Ажил, арга хэмжээ	Гүйцэтгэл	Хувь	Оноо
7.1. Хуулиар хүлээсэн үүргийн хүрээнд				
1	Аймгийн хэмжээнд 2014 онд иргэд олон нийтээс төрийн байгууллага, албан хаагчдын үйл ажиллагааны талаар авсан санал асуулгын дүгнэлт, өмнөх жилийн тайланд хийсэн үнэлгээ, АТГ-аас өгсөн чиглэл зөвлөмжинд тулгуурлан Авлигын эсрэг үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөг боловсруулж баталгаажуулж мөрдөх	Иргэд, олон нийтээс төрийн байгууллага, албан хаагчдын үйл ажиллагааны талаар авсан 2014 оны санал асуулгын дүгнэлт, өмнөх жилийн тайланд хийсэн үнэлгээ, Авлигатай тэмцэх газраас өгсөн чиглэл, зөвлөмжинд тулгуурлан аймгийн Засаг даргын Тамгын газрын авлигын эсрэг үйл ажиллагааны 2015 оны төлөвлөгөөг 2 бүлэг 38 ажил арга хэмжээтэйгээр боловсруулж, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажилласан.	100	
2	2012 оноос хойш баталж мөрдөж буй нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон аймгийн Засаг даргын шийдвэрийн хэрэгжилт олон нийтийн эрэлт хэрэгцээнд нийцэж байгаа эсэхийг судалж холбогдох арга хэмжээний санал боловсруулж шийдвэрлүүлэх Төрийн байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх аргачлалын 7.1.2 дахь шалгуурын дагуу зохион байгуулах	Аймгийн Засаг даргын 2012 оноос хойш гарч хүчин төгөлдөр мөрдөж байгаа нийтээр дагаж мөрдөх, хэм хэмжээ тогтоосон 5 захирамжийн хэрэгжилт иргэд, олон нийтийн хэрэгцээнд нийцэж байгаа эсэхийг Төрийн байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх аргачлалын 7.1.2 дахь шалгуурыг баримтлан нягтлан судлах ажиллагаа явуулсан. Энэхүү ажиллагаанаас өөрчлөлт оруулах, хүчингүй болгох зэрэг хэрэглэгч, хэрэгжүүлэгчдийн эрэлт шаардлагад нийцээгүй асуудал үүсээгүй гэсэн дүгнэлт гарч, аймгийн удирдлагад танилцуулагдсан.	100	
3	Авлигын эсрэг үйл ажиллагааг эрхлэх орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүн үйл ажиллагааны журмыг шинэчлэн гаргаж, гишүүдийн хариуцах ажлын цагалбар төлөвлөгөөг гаргаж,	Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2014 оны А/56 тоот тушаалаар томилогдсон 13 хүний бүрэлдэхүүнтэй орон тооны бус зөвлөлийг Авлигатай тэмцэх газрын даргын 2015 оны А/88 тоот тушаалаар үнэлэх аргачлал шинэчлэгдсэнтэй уялдуулан шинэчлэн томилгоожуулж, хариуцах ажлын цагалбаржсан төлөвлөгөөг гарган батлуулан ажиллалаа. Тайлант хугацаанд	100	

	хэрэгжилтийн явцыг хэлэлцэж холбогдох арга хэмжээ авах	Орон тооны бус зөвлөл 2 удаа бүрэн бүрэлдэхүүнээрээ, 4 удаа хэсэгчилсэн байдлаар хуралдаж ажил үүргийн хуваарийн дагуу хийсэн ажлаа зөвлөлдөн, харилцан мэдээлэл, санал солилцсон.		
4	Авлигын эсрэг хууль тогтоомж, үйл ажиллагааны төлөвлөгөө, хэрэгжилт, орон тооны бус зөвлөлийн ажлаас иргэд, байгууллага хамт олонд мэдээлэх, сурталчлах, ажлыг зохион байгуулах	<p>Авлигын эсрэг хууль тогтоомж, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, орон тооны зөвлөлийн ажлаас, байгууллагын хэмжээнд долоо хоног бүр зохион байгуулагддаг “Мэдээллийн цаг” арга хэмжээгээр хамт олонд 8 удаа тодорхой сэдэв чиглэлээр мэдээлэл хийгдсэн.</p> <p>Аймгийн хэмжээнд бүх сум тосгодыг хамран зохион байгуулагддаг уламжлалт “Ээлтэй үйлчилгээ–иргэн танд” нэгдсэн арга хэмжээний хүрээнд уг арга хэмжээг аймгийн Засаг даргын Тамгын газраас газар дээр нь зохион байгуулсан ажлын хэсгийн оролцоотойгоор иргэд, олон нийтийн дунд авлигын эсрэг хууль тогтоомж, үйл ажиллагааны төлөвлөгөө, хэрэгжилтээс мэдээлэх, сурталчлах ажлыг зохион байгуулсан.</p>     	100	
5	Иргэд, байгууллагын, авлигын эсрэг хууль тогтоомжийн болон хэрэгжилтийн мэдлэг, мэдээлэл авах нөхцөл боломжийг хангах зорилгоор аймгийн цахим хуудас, аймгийн ЗДТГ-ын сар тутмын “Өргөн Сэлэнгэ”	Авлигын эсрэг хууль тогтоомжийн болон хэрэгжилтийн мэдээлэл авах боломжоор хангаж, аймгийн “ Selenge.gov.mn ” цахим хуудсанд хууль тогтоомж, цаг үеийн хугацаат мэдээллүүдийг байршуулж, аймгийн Засаг даргын Тамгын газрын сар тутмын “ Өргөн Сэлэнгэ ” мэдээллийн сонинд авлигын эсрэг үйл ажиллагааны мэдээлэл авах утас, хаяг, холбогдох мэдээллийг	100	


	мэдээллийн сонинд тогтмол булан ажиллуулах	тогтмол хэлбэрээр нийтэлдэг болсон. Уг сонины өнгөрсөн жилийн тайлангаас хойшхи хугацаанд буюу 2014 оны 12 дугаар сарын дугаарт, Та үүнийг мэдэх үү буланд “АВЛИГА, БЭЛЭГ хоёрын ялгаа юу вэ? Зарим хүмүүс авлига, бэлэг хоёрыг адил зүйл гэх нь бий” , 2015 оны 1 дүгээр сарын дугаарт “Хөрөнгө орлогын мэдүүлэг гаргагч гэж хэн бэ” , 2 дугаар сарын дугаарт “Авлигатай тэмцэх газраас төрийн байгууллагуудын хэрэгжүүлж буй авлигын эсрэг үйл ажиллагааны тайлан” -ийн талаар зэрэг мэдээллийг тус тус нийтлүүлэн иргэд, олон нийтэд сурталчилсан.		
6	Төрийн хяналтын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах зорилгоор авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх хууль тогтоомжийн орон нутаг дахь хэрэгжилтэнд зөвлөн туслах үйлчилгээ зохион байгуулах	Төрийн хяналтын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах хүрээнд төрийн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлдэг байгууллагуудын үйл ажиллагааны төлөвлөгөөнүүдийг татан авч судлах, хяналт шалгалтын чиглэлээр төлөвлөгдсөн ажлуудаас нийтэд мэдээлэх боломжтойгоос нь аймгийн сар бүрийн нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөөнд тусган мэдээллийн хэрэгслүүдээр олон нийтэд ил тод мэдээлэх ажиллагаануудыг зохион байгуулсан. Энэ оноос эхлэн зохион байгуулагдаж байгаа “Хууль зүйн хэлтсийн өдөр” удирдамжит арга хэмжээгээр сумдын Бэлчир, Сэлэнгэ, Орхоны бүсийн сум тосгодын иргэд, төрийн албан хаагчдад авлигын эсрэг хууль тогтоомж, үйл ажиллагааны төлөвлөгөө, хэрэгжилтээр мэдээлэл өгч, зөвлөн туслах ажиллагаа явуулсан. Оны эхэнд гаргасан хуваарийн дагуу Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Байгаль орчин аялал жуулчлалын газар, Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтэс, Эрүүл мэндийн газар, Хөдөлмөрийн хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс, Стандартчлал хэмжил зүйн хэлтэс, Шүүх шинжилгээний алба, Улсын бүртгэлийн хэлтэс, Нэгдсэн эмнэлэг зэрэг байгууллагуудын дарга нарын шийдвэрийн эрх зүйн үндэслэлүүдийг хянаж, авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх хууль тогтоомжийн хэрэгжилтээр зөвлөн туслах үйлчилгээ зохион байгуулсан.	100	
7	Авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаатай холбогдолтой сурталчилгаа мэдээллийн	Авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаатай холбогдолтой сурталчилгаа мэдээллийн хуудас, материалын түгээлтийг бүртгэлжүүлж, ашиглалтанд хэсэгчилсэн		

	<p>хуудас, материалын түгээлт, ашиглалтыг бүртгэлжүүлэх, ашиглалтыг хянан зохицуулах ажил зохион байгуулах</p>	<p>хяналт зохион байгуулсан. Тайлант онд Авлигатай тэмцэх газраас “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтан нарт зориулсан” гарын авлага, “Нийтийн албан тушаалтнуудад зориулсан гарын авлага”, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг, мэдэгдэл, тайлбар гаргах, их хэмжээний өөрчлөлт болон хуулийн хугацаа сануулсан 4 төрлийн зурагт хуудас /плакат/-ыг салбар эрх бүхий албан тушаалтнуудад бүртгэлээр түгээж, албан тушаалтнуудын өрөө, байгууллагуудын мэдээллийн самбар болон олонд хүрэх байршлуудад байршуулан ажиллалаа.</p>	100	
8	<p>Аймгийн ИТХ, Засаг даргаас 2015 онд шинээр боловсруулан гаргахаар төлөвлөсөн бодлогын болон гийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоох шийдвэрийнжагсаалтыг нэгтгэж аймгийн цахим хуудсаар нийтэд мэдээлэх</p>	<p>Аймгийн ИТХ, Засаг даргаас 2015 онд боловсруулан гаргахаар холбогдох төлөвлөгөөнүүдэд тусгагдсан дараах бодлогын баримт бичиг, шийдвэрийн төслүүдийг аймгийн цахим хуудас, аймгийн төрийн байгууллагуудад энэ оноос нэвтрээд байгаа “Байгууллагын удирдлагын цогц систем - “able cloud” програмаар олон нийтэд хүргэж санал авах, Тамгын газарт нэвтэрч буй чанарын удирдлагын тогтолцоо, ISO 9001:2008 стандартын хэрэгжилтийг хангах үүрэг бүхий байгууллагын “Чанарын баг” – аар хэлэлцүүлэх арга ажиллагаануудыг явуулж хэвшээд байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Цахим сургууль аймгийн хөтөлбөр • Багшийн хөгжил аймгийн хөтөлбөр • Уул уурхайн талаар баримтлах аймгийн бодлого • Хог хаягдал цуглуулах тээвэрлэх, устгах ажиллагааг санхүүжүүлэх, хог тээвэрлэгчийг сонгон шалгаруулах, хог хаягдлын үйлчилгээний хураамжийг төвлөрүүлэхэд мөрдөх журам • Усан хангамж, ариутгах татуургын талаар баримтлах бодлого • Ойгоос мод шилжүүлэн суулгах журам • Хүн амыг хүнсний уурагт бүтээгдэхүүнээр жигд хүртээмжтэй хангах зорилго бүхий “Загас” хөтөлбөр • “Аймгийн концессын гэрээгээр гүйцэтгэх ажлын жагсаалт • Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 	100	


		<p>Сэлэнгэ аймгийн 2015-2018 оны төлөвлөгөө</p> <ul style="list-style-type: none"> • Аймгийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх аж ахуй нэгжид зөвшөөрөл олгох, зөвшөөрлийг түдгэлзүүлэх, цуцлах, сэргээх үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулах журмын шинэчилсэн төсөл • Сэлэнгэ аймагт төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагуудын 50 болон түүнээс дээш 10 жилийн давтамжтай түүхэн тэгш ой тэмдэглэхэд мөрдөх журам • Шинээр боловсруулан гаргаж байгаа бодлогын баримт бичиг, нийтийн хамаарал бүхий шийдвэрийн төсөлд санал авах журам 		
9	Дээрх жагсаалтад орсон шийдвэрийн төслүүдийг аймгийн цахим хуудсанд байршуулах, олон нийтэд танилцуулах, санал авах ажил зохион байгуулах	Өмнөх хэсэгт тайлагнагдсан 7 бодлогын баримт бичиг, 4 журмын төслийг аймгийн цахим хуудас, “Байгууллагын удирдлагын цогц систем - “able cloud” програмаар олон нийтэд хүргэж санал авч нэгтгэн, Тамгын газарт нэвтэрч буй чанарын удирдлагын тогтолцоо, ISO 9001:2008 стандартын хэрэгжилтийг хангах үүрэг бүхий байгууллагын “Чанарын баг” –аар хэлэлцүүлэх арга ажиллагаануудыг нэвтрүүлэн ажиллаж байна.	100	
10	Нутгийн өөрөө удирдах ёсны болон захиргааны байгууллага, хууль сахиулах, хяналт шалгалтын байгууллагуудаас зохион байгуулах хяналт шалгалтын төлөвлөгдсөн ажлуудыг судалж нэгтгэн нийтэд мэдээлэх арга хэмжээ авах	Энэ онд төлөвлөгдсөн хяналт шалгалтын ажлуудаас олон нийтэд хамааралтай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 5, Мэргэжлийн хяналтын газрын 12, Байгаль орчны газрын 4, Цагдаагийн газрын 5, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны 2 нийт 26 хяналт шалгалтын хугацаа, хамрах хүрээ, хариуцагчийн мэдээлэл, хяналт шалгалтын дүн, шалгалтын мөрөөр авсан ажил арга хэмжээнүүдээс байгууллагуудын мэдээллийн самбар, цахим хуудсуудаар нийтэд мэдээлэгдсэн. Шилэн дансны тухай хуулийн дагуу шилэн дансны мэдээлэл байршиж байгаа эсэх, түүний чанарын талаарх хяналтыг аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас авлигын эсрэг орон тооны зөвлөлд энэ ажлыг хариуцсан албан тушаалтан хариуцан ажиллаж, улирал, хагас жилд тутамд аймгийн Засаг даргад тайлагнаж, аймгийн цахим хуудаснаа	100	

		байршуулж ажилласан. Мөн аймгийн Аудитын газраас хийгддэг гүйцэтгэлийн аудит болон бусад шалгалтын тайланг аймгийн цахим хуудсанд байршуулж олон нийтэд мэдээлж ажилласан.		
11	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, төсвийн орлого, зарцуулалт, гадаадын зээл, тусламжийн хуваарилалт зардлын гүйцэтгэлийг олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулах	Оны эхэнд аймгийн Засаг даргаас аймаг дахь төсвийн шууд захирагч нарт “Шилэн дансны тухай хууль” ийн хэрэгжилтийг сайн хангахад анхаарах бодлогын шинжтэй үүрэг даалгаврыг албажуулан өгч, хэрэгжилт, үр дүнг тооцон ажиллаж байна. Аймгийн www.selenge.gov.mn сайтанд аймгийн хэмжээний бүх байгууллагын линкийг холбож шилэн дансны мэдээллийг шуурхай үзэх боломжийг хангаж ажилласан бөгөөд энэ нь иргэд олон нийтийн сэтгэл ханамжид хүрсэн ажил болж байна.	100	
12	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь олон нийтэд мэдээлэх	Сэлэнгэ аймгийн 2014 оны төсвийн гүйцэтгэлийн тайланд хийгдсэн аудитын дүгнэлт болон 2015 оны хагас жилийн тайлан зэргийг бүрэн эхээр нь аймгийн цахим хуудсанд байршуулан олон нийтэд хүргээд байна.	100	
13	Тухайн жилийн төсөвт орсон өөрчлөлтийг олон нийтэд мэдээлэх	2014 оны 12 сарын 04-ны өдрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “ 2015 оны төсөв батлах тухай” 56 дугаар тогтоол, 2015 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 61 тоот “Сэлэнгэ аймгийн 2015 оны тодотгосон төсөв батлах тухай” тогтоол, 2015 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 69 тоот “Сэлэнгэ аймгийн 2015 оны тодотгосон төсөв батлах тухай” тогтоолуудыг аймгийн www.selenge.gov.mn сайтанд байршуулж төсвийн өөрчлөлт, аймгийн нийгэм эдийн засгийн байдлын талаарх мэдээ мэдээллийг шуурхай мэдээлж ажилласан. Ийнхүү тайлант хугацаанд аймгийн төсөвт 2 удаа өөрчлөлт орж мэдээлэгдсэн.	100	
14	Тухайн жилийн төсвийн хөрөнгө оруулалт, зарцуулалтыг олон нийтэд мэдээлэх	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар 2015 оны аймгийн төсвийн хөрөнгө оруулалт 1042,9 сая төгрөг, замын сангийн хөрөнгө оруулалт 378,9 сая төгрөг, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт 2173,4 сая төгрөг батлагдсан. Эдгээр хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлийн мэдээг www.selenge.gov.mn болон холбогдох байгууллагуудын мэдээлэлд сар бүр оруулж олон нийтэд ил тод мэдээлж байна. Мөн аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн ил тод байдлын самбарт хөрөнгө оруулалтын санхүүжилт гүйцэтгэлийн мэдээг гаргаж олон нийтэд хүргэж ажиллаж байна. ЗГХЭГ, Сангийн яам, эрх бүхий байгууллагын үнэлгээгээр тус аймаг,	100	

		Шилэн дансны мэдээллийг цахми хуудаснаа үлгэр жишээ байршуулдаг үнэлгээ дүгнэлтийг аваад байна. Мөн аймгийн орон нутгийн хөгжлийн сан, сумдын орон хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг Орон нутгийн хөгжлийн сангийн програмд шивж олон нийтэд нээлттэй мэдээллэх техникийн нөхцөл, боломжийг бүрэн бүрдүүлэн ашиглуулж байна.		
15	Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл хөтөлбөр, хэрэгжилтийг олон нийтэд мэдээлэх	Тайлант онд тус аймагт Япон Улсын Засгийн газрын “Өвсний үндэс” хөтөлбөрийн тусламжийн 30,0 сая төгрөгийн хөрөнгөөр Түшиг сумын 12 жилийн бүрэн дунд сургуулийн дотуур байрны барилгад их засварын ажил хийгдсэн. Энэ тусламжийн хөрөнгийн хэмжээ, гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтын мэдээлэл, барилгын засварын ажлын гүйцэтгэлийг тухай бүрд нь орон нутгийн телевиз, сонин, мэдээллийн самбарт тавьж олон нийтэд ил тод мэдээлж ажилласан.	100	
16	Нийгмийн даатгал, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн сан, Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан зэргээс тэтгэвэр, тэтгэмж, зээл, тусламж авагчдыг олон нийтэд мэдээлэх	Аймгийн Хөдөлмөрийн хэлтсийн мэдээллийг “selenge.hudulmur.gov.mn” , Халамж үйлчилгээний хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтсийн мэдээллийг www.selenge.gov.mn цахим хуудас, сумдын Засаг даргын Тамгын газрын мэдээллийн самбаруудаар нийгмийн даатгал, нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлтийн сангуудаас тэтгэвэр, тэтгэмж, тусламж авч буй 32875 иргэдийн, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас зээл авсан 280 иргэн, аж ахуйн нэгжийн мэдээллийг олон нийтэд сар, улирлаар мэдээлсэн. Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авагч нийт 17259 үүнээс өндөр настны тэтгэвэр авагч 10138 иргэний мэдээлэл улсын хэмжээний цахим сүлжээнд бүрэн байршиж ашиглагдаж байна.	100	
17	Байгууллагаас олгож байгаа тусгай зөвшөөрлийн мэдээллийг, Төрийн байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх аргачлалын 7.1.8 дахь шалгууруудын дагуу олон нийтэд хүргэх	Аймгийн Засаг даргын Тамгын газраас Ерөнхий боловсролын сургуулийн сургалт эрхлэх, Сургуулийн өмнөх боловсролын сургалт эрхлэх, Хүн эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх, Эмийн сангийн үйлчилгээ эрхлэх, Архи, согтууруулах ундаа үйлдвэрлэх, түүгээр үйлчлэх, Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын гэсэн 6 төрлийн тусгай зөвшөөрлийг зохих хууль тогтоомжийг баримтлан олгож байна. Тайлант онд дээрх ажлын хүрээнд шинээр 3 аж ахуйн нэгж, байгууллагад тусгай зөвшөөрөл олгож, 74 аж ахуйн нэгж, байгууллагын	100	


		<p>зөвшөөрлийн хугацааг сунгаж, 3 аж ахуйн нэгж, байгууллагад олгосон тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох үйлчилгээг үзүүлсэн байна.</p>		
18	<p>Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангах ажлыг Төрийн байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх аргачлалын 7.1.6 дахь шалгууруудын дагуу зохион байгуулах</p>	<p>Аймгийн Засаг даргаас 2015 оныг <u>“Иргэн таны төлөө”</u>, Аймгийн Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс “Нэгжийн менежерүүдийн манлайллыг дээшлүүлэх жил” болгон зарлаж түүнийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “69 багц ажлын чиглэл”-ийг боловсруулан гаргаж хэрэгжилтийн явц үр дүнг тооцон ажиллаж байна.</p> <p>Орон нутгийн төрийн захиргааны байгууллагын сул орон тооны захиалгыг нэгтгэн эхний 10 сарын байдлаар нийт 36 албан тушаалын сул орон тоог Төрийн албаны зөвлөлийн <u>“csc.gov.mn”</u> цахим хуудсанд байршуулан нийтэд ил тод мэдээлж, төрийн албаны мэргэшлийн шалгалтыг 2 удаа цахим хэлбэрээр зохион байгуулсан.</p>  <p>Төрийн албаны мэргэшлийн шалгалтын явцыг иргэд, олон нийтэд нээлттэй болгох зорилгоор улсад анх удаа телекамерийн хяналтын систем нэвтрүүлэх ажлыг санаачлан хэрэгжүүлсэн.</p>	100	

		Тайлант онд аймагт зохион байгуулагдсан 2 удаагийн мэргэшлийн шалгалтын сүүлчийнх энэ сарын 9, 10 ны өдрүүдэд болж, шалгалтанд орсон 239 хүний 63 нь буюу 26.3 хувь нь шалгалтанд тэнцсэн дүнтэй байна.		
19	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах ажлыг Төрийн байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх аргачлалын 7.1.7 дэх шалгууруудын дагуу зохион байгуулах	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Боловсрол, соёл шинжлэх ухааны яам, Эрчим хүчний яамны захиалгатай 4 тендер зарласанаас харьцуулалтын аргаар 3, нээлттэй тендер шалгаруулалтаар 1-ийг зарлаж, урилгыг “Зууны мэдээ” сонины 2015 оны 7-р сарын 28, дугаар, Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх 4 тендер зарласнаас харьцуулалтын аргаар 2, нээлттэй тендер шалгаруулалтаар 2, урилгыг “Зууны мэдээ” сонины 2015 оны 5-р сарын 12-ны өдрийн, 5-р сарын 08-ны өдрийн дугааруудад, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх 13 ажлын тендерийн урилгыг “Зууны мэдээ” сонины 2015 оны 03-р сарын 18-ны өдрийн дугаар, Замын сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх 4 тендер зарласнаас харьцуулалтын аргаар 2, нээлттэй тендер шалгаруулалтаар 2, урилгыг “Зууны мэдээ” сонины 2015 оны 5-р сарын 08-ны өдрийн, Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар 2 тендер зарласнаас харьцуулалтын аргаар 1, нээлттэй тендер шалгаруулалтаар 1, урилгыг “Зууны мэдээ” сонины 2015 оны 03-р сарын 25-ны өдрийн, Хандив, зээл, тусламжаар 5 тендер зарласнаас харьцуулалтын аргаар 1, нээлттэй тендер шалгаруулалтаар 4, урилгыг “Зууны мэдээ” сонины 2015 оны 4-р сарын 20, 5-р сарын 12, 27, 7-р сарын 01, 21-ны өдрийн дугааруудад, Засаг даргын нөөцийн сангаас 1 тендер зарласнаас нээлттэй тендер шалгаруулалтаар 1, урилгыг “Зууны мэдээ” сонины 2015 оны 3-р сарын 11-ны өдрийн дугааруудад тус тус нийтлүүлж олон нийтэд мэдээлсэн.	100	

		<p style="text-align: center;">Бараа, ажил үйлчилгээ худалдан авалт</p>  <table border="1" data-bbox="1624 311 1915 901"> <thead> <tr> <th>Хөрөнгө оруулалтаар</th> <th>Хэмжээ</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар</td> <td>311300</td> </tr> <tr> <td>Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар</td> <td>890389.8</td> </tr> <tr> <td>Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар</td> <td>1085217.4</td> </tr> <tr> <td>Замын сангийн хөрөнгө оруулалтаар</td> <td>378900</td> </tr> <tr> <td>Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар</td> <td>322000</td> </tr> <tr> <td>Хандив, зээл, тусламж</td> <td>916387.5</td> </tr> <tr> <td>Бусад</td> <td>397419.7</td> </tr> </tbody> </table>	Хөрөнгө оруулалтаар	Хэмжээ	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар	311300	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар	890389.8	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар	1085217.4	Замын сангийн хөрөнгө оруулалтаар	378900	Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар	322000	Хандив, зээл, тусламж	916387.5	Бусад	397419.7		
Хөрөнгө оруулалтаар	Хэмжээ																			
Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар	311300																			
Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар	890389.8																			
Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар	1085217.4																			
Замын сангийн хөрөнгө оруулалтаар	378900																			
Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар	322000																			
Хандив, зээл, тусламж	916387.5																			
Бусад	397419.7																			
20	Байгууллагын ажилтнуудын чиг үүрэг, ажлын байрны тодорхойлолтыг шинэчилж мөрдүүлэх ажлыг зохион байгуулах	Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын тушаалаар ажилтнуудын “Ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэх ажлын хэсэг” томилон ажиллуулж, “Тавигдах шаардлага” хэсэгт авлига, ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах талаар тусгаж нийт 38 ажилтны ажлын байрны тодорхойлолтыг, 42 ажилтны хөдөлмөрийн гэрээг шинэчлэх арга хэмжээг авч мөрдүүлсэн.	100																	
21	Аймгийн Засаг даргаас төрийн бус байгууллагатай тодорхой ажил, үйлчилгээг сонгон шалгаруулалтаар гүйцэтгүүлэх, хамтран ажиллах гэрээ байгуулах, үр дүнг тооцох, олон нийтэд мэдээлэх	Аймгийн Засаг даргаас 2015 онд аймагт идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй <i>Авлигаас урьдчилан сэргийлэх Төрийн бус байгууллагын сүлжээ, Хэрэглэгчдийн эрхийг хамгаалах нийгэмлэг, Улаан загалмайн нийгэмлэг, Эмэгтэйчүүдийн холбоо, Ажил олгогч эздийн холбоо, Үйлдвэрчний эвлэлийн холбоо, Барселон олимпийн зөвлөл, Уяачдын холбоо, Хөдөлмөр</i>	100																	

		<p>нийгмийн зөвшилт 3 талт салбар хороо, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн Сэлэнгэ аймаг дахь салбар, Ахмадын хороо, Хараагүйчүүдийн холбоо, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн салбар хороо зэрэг 13 төрийн бус байгууллагатай тодорхой ажил үүргийг гүйцэтгүүлэх, хамтран ажиллах гэрээг гүйцэтгэх ажил үйлчилгээнд нь сонгон шалгаруулалт явуулах зарчимаар, байгуулан ажиллаж үйл ажиллагаанд нь гэрээний дагуу нийт 27,5 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлж үр дүнг улирлаар тооцон ажиллаж байна.</p> <p>Авлигаас урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх болон авлигын эсрэг явуулж буй төрийн байгууллагын үйл ажиллагааны мэдээллийг олон нийтэд хүргэхэд төв, орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллага ажилтнуудтай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна. Энэ хүрээнд тайлант онд төвийн “Зууны мэдээ” сонин, орон нутгийн “Сэлэнгийн мэдээ”, “Шинэ гэгээ” сонин, “Миний Монгол”, “Таны Сэлэнгэ” КТВ, “Өргөн сэлэнгэ” FM болон телевизийн чиглэлийн 5 чөлөөт уран бүтээлчидтэй гэрээ байгуулан хамтран ажиллаж, аймгийн төсвөөс 11.6 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж үйл ажиллагаанд нь гэрээлсэн хөлсийг гүйцэтгэлээр тооцон олгож ажилласан.</p>		
22	Байгууллагын ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангах	Өмнө нь батлагдаж мөрдөгдөж байсан “Аймгийн Засаг даргын Тамгын газарт мөрдөх ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрэм”, “Аймгийн Засаг даргын зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ыг шинэчлэн тодотгож зөвлөлийн гишүүдийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд баримтлах зарчмыг шинээр томъёолж мөрдөх зэрэг арга хэмжээг тайлант онд аваад байна.	100	
23	Давхар ажил эрхэлж болох ажлын жагсаалт, судалгаа гаргаж хамт олонд танилцуулж мэдээлэх	Давхар ажил эрхэлж болох ажил, албан тушаалын судалгаа явуулж, судалгааны дүнд тулгуурлан жагсаалт гаргах оролдлого хийсэн дүнгээ байгууллага хамт олонд танилцуулж, тийм ажил одоогоор байхгүй гэдэгт санал нийлсэн.	100	
24	Аймгийн Засаг дарга, Тамгын газраас гаргаж байгаа шийдвэрийн ил тод байдлыг хангах ажлыг Төрийн байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх аргачлалын 7.1.13	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга нарын тогтоол, захирамж, тушаалыг тухай бүр аймгийн албан ёсны цахим хуудасны “Хууль эрх зүй” цэсний Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, “Ил тод байдал” цэсний Худалдан авах ажиллагааны тендер	100	

	дахь шалгууруудын дагуу зохион байгуулах	шалгаруулалт дотор байршуулж иргэд, олон нийтэд мэдээлж ажилласан. Авлигатай тэмцэх газраас хийсэн шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгуулах ажлыг зохион байгуулж аймгийн болон Шаамар, Алтанбулаг, Сайхан, Номгон тосгон сумдын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга нарын гаргасан зарим захирамж, тушаалуудыг хүчингүй болгуулах ажлыг зохион байгуулсан, Шаамар, Баянгол, Хүдэр, Ерөө сумдын Засаг дарга нарт аймгийн Засаг даргын захирамжаар сахилгын шийтгэл ногдуулсан. Авлигатай тэмцэх газрын шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулах, ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн Засаг даргын 1 захирамж, 1 төлөвлөгөө гаргаж, 3 албан тоотыг сум, хэлтэс, албад хүргүүлж зөрчлийг арилгуулах ажил, арга хэмжээнүүдийг зохион байгуулж, тайлан мэдээг тухай бүр Авлигатай тэмцэх газарт хүргүүлж ажилласан.		
25	Иргэдийн санал өргөдөл гомдолтой холбогдсон ажил үйлчилгээг Төрийн байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх аргачлалын 7.1.14 дахь шалгууруудын дагуу зохион байгуулах	Иргэдийн санал өргөдөл гомдолтой холбогдсон ажил үйлчилгээг Төрийн байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх аргачлал, шалгууруудын дагуу зохион байгуулах хүрээнд аймгийн Засаг даргын Тамгын газарт иргэд олон нийтийн санал хүсэлтийг хүлээн авах <u>7036-1111</u> шууд утас ажилуулах, энэ ажлыг хариуцсан орон тооны ажилтан ажиллуулах ажиллагаагаа тайлант онд үргэлжлүүлсэн. Орон нутгийн “Миний монгол” телевизэд <i>“Иргэдээ сонсьё”</i> шууд нэвтрүүлгийг оны эхэнд баталсан хуваариар тогтмол цагт явуулж, тайлант онд 24 байгууллага оролцсон 43 удаагийн нэвтрүүлэг хийгдээд байна. Аймгийн удирдлага, төрийн үйлчилгээний байгууллагууд олон нийтэд мэдээлсэн хуваарийн дагуу уг нэвтрүүлэгт оролцож иргэдийн үгийг сонсож, авсан арга хэмжээгээ хариу мэдээлж байна. Тайлант онд аймгийн Засаг дарга, ажлын албанд 278 өргөдөл, гомдол хүлээн авч хугацаанд нь бүрэн шийдвэрлэж хариуг өгсөн. <u>Дээрх өргөдөл, санал, хүсэлтийг агуулгаар нь авч үзвэл:</u> Буцалтгүй тусламж хүсэх тухай өргөдөл 30 10,9 % Ажилд орох тухай өргөдөл 26 9,3 % Ажлын байр түрээслэх 51 18,3 % Төрийн байгууллага, албан тушаалтны тухай	100	

		<p>гомдол 28 10 % Бусад асуудлаар гаргасан өргөдөл 143 51,4 % тус тус байна. Засгийн газрын 1111 төвөөс өнгөрсөн хугацаанд Сэлэнгэ аймагт холбогдолтой нийт 5 санал хүсэлт шилжүүлэн ирүүлснийг хугацаанд нь шийдвэрлэж хариуг мэдээлсэн</p> <div data-bbox="974 335 1935 933" style="border: 1px solid black; padding: 10px; text-align: center;"> <h3>Санал, өргөдөл, гомдол</h3>  <table border="1" style="margin-left: auto; margin-right: auto;"> <thead> <tr> <th>Категори</th> <th>Тоо</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>буцалтгүй тусламж хүссэн</td> <td>26</td> </tr> <tr> <td>Ажилд орохыг хүссэн</td> <td>30</td> </tr> <tr> <td>Ажлын байр түрээслэх</td> <td>51</td> </tr> <tr> <td>Төрийн байгууллага албан тушаалтны тухай</td> <td>28</td> </tr> <tr> <td>Бусад</td> <td>143</td> </tr> <tr> <td>НИЙТ</td> <td>278</td> </tr> </tbody> </table> </div>	Категори	Тоо	буцалтгүй тусламж хүссэн	26	Ажилд орохыг хүссэн	30	Ажлын байр түрээслэх	51	Төрийн байгууллага албан тушаалтны тухай	28	Бусад	143	НИЙТ	278		
Категори	Тоо																	
буцалтгүй тусламж хүссэн	26																	
Ажилд орохыг хүссэн	30																	
Ажлын байр түрээслэх	51																	
Төрийн байгууллага албан тушаалтны тухай	28																	
Бусад	143																	
НИЙТ	278																	
26	<p>Авлигын эрсдэл, авлига гарах боломжийг бууруулах, авлига, ашиг сонирхлын зөрчилтэй ажил, асуудлыг Төрийн байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх аргачлалын 7.1.15 дахь шалгуурын дагуу зохион байгуулах</p>	<p>Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн 2015 оны 05/1728, 01/25 тоотор ирүүлсэн “<i>Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон Авлигын эсрэг хуулийг хэрэгжүүлэн ажиллах</i>”-тай холбоотой хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, энэ оны 02/5676 тоотор ирүүлсэн Мэдээлэл хүргүүлэх тухай албан тоот, Аймгийн Засаг даргын 2015 оны 10-р сарын 12-ны өдрийн А/412 тоот захирамжинд Төрийн байгууллагуудаас явуулж буй авлигын эсрэг хууль болон ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор авлигын эсрэг шуурхай арга хэмжээ зохион байгуулах сарын аяныг аймгийн хэмжээнд 2015 оны 10-р сарын 07-ны өдрөөс эхлэн зохион байгуулах тухай сум, хэлтэс, албадад үүрэг өгч хэрэгжүүлэх</p>	100															

		ажлыг зохион байгуулсан. Мэдүүлэг бүрдүүлэлтийн хяналт шалгалтын дүнгийн тухай 01/6719 тоотын дагуу шалгалтын мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөө гарган батлуулан аймгийн Засаг дарын захирамж 1, хууль тогтоомжид заасны дагуу аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын даргаас олгож буй тусгай зөвшөөрөлтэй холбоотой олгодог үйл ажиллагаа, шийдвэрт холбогдох албан тушаалтнаас тухайн шийдвэрийг шийдвэрийг гаргах буюу тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүсч байгаа эсэх талаар бичгээр тайлбар гаргаж, бүрдлийг нь аймгийн эрх бүхий албан тушаалтан хөтлөх ажиллагаанд шилжүүллээ.		
27	Авлигатай тэмцэх газраас гаргасан шийдвэрийг биелүүлэх ажлыг Төрийн байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх аргачлалын 7.1.17 дахь шалгууруудын дагуу зохион байгуулах	Авлигатай тэмцэх газрын даргын 2015 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн <u>“Үнэлгээний дүнгийн тухай” 01/460</u> албан тоотор ирүүлсэн 8 сөрөг арга хэмжээг арилгах ажлын төлөвлөгөө гарган тамгын газрын даргаар батлуулан зохион байгуулж, зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан. Монгол улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газрын 2015 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн <u>Мэдээлэл хүргүүлэх тухай</u> 748 албан тоотор ирүүлсний дагуу Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, Авлигын ерөнхий нөхцөл байдлын талаарх мэдээллийг бэлтгэн гаргаж ажиллаж байна.	90	
7.2. Авлигатай тэмцэх санал, санаачилгын хүрээнд				
28	Сумын Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллагаанд үнэлгээ хийх аргачлал боловсруулж мөрдөх	“Сэлэнгэ аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний төрийн байгууллага, сумын Засаг даргын Тамгын газрын авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх аргачлал” –ыг аймгийн хэмжээнд мөрдөхөөр төслөөр боловсруулж санал авах ажиллагаанд шилжүүллээ байна. Аймгийн хэмжээнд 2012 оноос эхлэн хэрэгжүүлж буй төрийн байгууллага, албан хаагчдын үйл ажиллагааны үнэлгээнд иргэдээс <u>“Санал асуумжийн хуудас”</u> -аар санал авч харгалздаг арга ажиллагаандаа энэ онд ухаалаг төрийн зарчимд нийцүүлсэн зарим өөрчлөлт хийсэн. Энэ онд уламжлалын дагуу бүх сум, тосгодыг хамруулан зохион байгуулагдсан <u>“Ээлтэй үйлчилгээ – иргэн танд”</u> нэгдсэн арга хэмжээгээр нийт 19460 иргэнээс 13 байгууллага, тэдгээрт ажиллаж буй албан хаагчдын үйл ажиллагаанд санал асуумжаар үнэлгээ авч нэгтгэн мэдээлж, жилийн ажлын үнэлгээнд харгалзахад бэлэн болгоод байна. Аймгийн Засаг даргын Тамгын	100	

		<p>газарт 2012 оноос нэвтрүүлж буй <u>Чанарын удирдлагын тогтолцоо ISO 9001:2008</u> стандартын хэрэгжилтийн явцад Герман-Монголын хамтын ажиллагааны нийгэмлэгийн дэмжлэгээр Чанарын удирдлагын тогтолцооны тэргүүлэх аудитор Б.Гэрэлээр хөндлөнгийн аудит хийлгэж, гаргасан дүгнэлт зөвлөмжийн дагуу хийх ажлаа төлөвлөн хэрэгжүүлж, түүндээ дотоод аудитийн баг томилон ажиллуулж үр дүнгээ хамт олноороо хэлэлцэх арга хэмжээ аван ажиллаж байна. Үүний үр дүнд Стандартчилал хэмжил зүйн газрын баталгаажуулалтын хурлаар хэлэлцэж, Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газарт Чанарын удирдлагын тогтолцоо MNS ISO 9001:2010 стандартыг хэрэгжүүлснийг баталгаажуулан гэрчилгээ олгохоор шийдвэрлэлээ. Аймгийн Засаг даргын Тамгын газар “Үйл ажиллагааны нийцлийн аудит”–ыг аймгийн Аудитийн газраар хийлгэж, гарсан дүгнэлт зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээг авсан. Дээрх аудит, хяналт шалгалтуудаар авлигын зөрчил илрээгүй. Аймгийн Засаг даргын 2015-10-12-ний өдрийн “Авлигын эсрэг сарын аян зохион байгуулах тухай” А/412 дугаар захирамж гаргаж нутгийн захиргааны байгууллага, төрийн байгууллага, албан хаагчдын үйл ажиллагааг ил тод болгох, авлигын эсрэг хууль болон ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор авлигын эсрэг шуурхай арга хэмжээ зохион байгуулан ажиллалаа. Энэхүү ажлын хүрээнд аян зохион явуулах төлөвлөгөө гарган баталгаажуулж, хэрэгжилтийг хангуулах, явц, үр дүнг тооцох ажиллагаанууд явагдаад байна.</p>		
29	<p>Албан хаагчдын шударга байдал ба түүнийг нэмэгдүүлэхэд чиглэсэн шударга ёс, ёс зүй, сонирхлын зөрчлийн талаарх сургалт, хэлэлцүүлэг, ярилцлага, өдөрлөг зохиох зөвлөмж өгөх</p>	<p>Авилгатай тэмцэх, урьдчилан сэргийлэх хууль тогтоомжийн орон нутаг дахь хэрэгжилтийг шалган зөвлөн туслах ажлыг, энэ оноос эхлэн зохион байгуулж байгаа “Хууль зүйн хэлтсийн өдөр” удирдамжит арга хэмжээгээр зохион байгуулж байна. Энэ арга хэмжээг тайлант онд Сэлэнгэ, Бэлчир, Орхоны бүсийн 11 сумдад зохион байгуулж, төрийн албан хаагчдад “Авлига, ашиг сонирхлын зөрчил ба ил тод байдал” сэдвээр сургалт явуулж, эрх бүхий албан тушаалтаны ажлыг шалган зөвлөгөө өгөх ажиллагаа явуулсан. Сумдаар ажиллахдаа байгууллагуудын даргын тушаалын эрх зүйн үндэслэлийг шалгаж, илэрсэн зөрчил</p>	100	

		дутагдлуудыг арилгуулах, хууль хэрэгжүүлэхтэй холбоотой ажлуудыг зохион байгуулсан. “Ээлтэй үйлчилгээ, иргэн танд” нээлттэй хаалганы өдрөөр Дулаанхаан, Шаамар, Түшиг, Цагааннуур, Зүүнбүрэн, Алтанбулаг сумдаар ажиллаж сумдын ХАСХОМ хариуцсан эрх бүхий албан тушаалтнуудад гарын авлага, тараах материалууд өгч зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн.		
30	Нутгийн захиргааны байгууллага, төрийн албан хаагчдын үйл ажиллагааны үнэлгээнд иргэд олон нийтийн санал авч харгалздаг арга хэлбэрээ ухаалаг төрийн зарчимд нийцүүлэн сайжруулж мөрдөх	Төрийн байгууллагуудын ажил үйлчилгээ, төрийн албан хаагчийн ажлын хариуцлага, ёс зүй, тэдгээрийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшнийг иргэдийн сэтгэл ханамж, үнэлэмжид тулгуурлан үнэлэх зорилгоор “Олон нийтийн оролцоо-төрийн үйлчилгээ” хөтөлбөрийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 165 дугаар тогтоолоор батлуулж, хэрэгжүүлэн ажиллаж байна. “Үйлчлүүлэгчдээс Төрийн байгууллага, албан хаагчдын үйл ажиллагааны талаар санал асуулга авах журам”-ыг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн аймгийн Засаг даргын захирамжаар баталгаажуулан мөрдөж ажилласан нь иргэдийн гомдол санал багасч байна. Аймгийн хэмжээнд бүх сум тосгодыг хамран зохион байгуулагддаг уламжлалт “Ээлтэй үйлчилгээ–иргэн танд” нэгдсэн арга хэмжээний хүрээнд уг арга хэмжээг аймгийн Засаг даргын Тамгын газраас газар дээр нь зохион байгуулсан ажлын хэсгийн оролцоотойгоор иргэд, олон нийтийн дунд авлигын эсрэг хууль тогтоомж, үйл ажиллагааны төлөвлөгөө, хэрэгжилтээс мэдээлэх, сурталчлах ажлыг зохион байгуулсан. Энэ арга хэмжээний үеэр нийт 1295 иргэнээс төрийн байгууллага, албан хаагчдын үйл ажиллагаа, үйлчилгээний талаар санал асуулга авч нэгтгэн гаргаж ажиллалаа.	100	
31	Авлигын эсрэг төрийн бус байгууллагын сүлжээтэй хамтран ажиллах гэрээ байгуулж үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх	Авлигаас урьдчилан сэргийлэх Төрийн бус байгууллагын сүлжээнд аймгийн Засаг даргаас 2015 онд 1.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлж, сүүлийн 3 жилд хийсэн ажлын тайланг нийтэд мэдээлүүлэх ажлыг зохион байгуулж, гарсан санал санаачилагуудыг төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлж байна.	100	

32	<p>Аймгийн Засаг даргын Тамгын газрын “Нэгжийн менежерийн манлайлалыг дээшлүүлэх жил”-ын зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд хийгдэж буй байгууллагын удирдлага, нэгжийн менежерүүдийн авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэл, санал санаачилгуудыг дэмжих, мэдээлж сурталчлах ажиллагаа явуулах</p>	<p>Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2015 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн Б/02 тоот тушаалаар “Нэгжийн менежерүүдийн манлайллыг дээшлүүлэх жил” болгон зарлаж, зарласан жилийн хүрээнд хариуцсан нэгжийнхээ үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангах, арга хэмжээг санаачлан зохион байгуулах, мөн байгууллага хамт олны идэвх санаачлагыг өрнүүлэх, дэмжих зэргээр үйл ажиллагааны төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх ажлыг удирдлага зохион байгуулалтаар хангаж, жилийн эцэст зарласан жилийн дүнг тооцож үнэлэлт өгөхөөр ажиллаж байна. Зарласан жилийн зорилтын хэрэгжилтийг хангах төлөвлөгөөг менежерүүд тус бүрдээ гарган батлуулан ажиллаж байна.</p>	100	
33	<p>Авлигад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаал, ажил үйлчилгээний судалгааг байгууллагын болон аймгийн төрийн байгууллагын хэмжээнд явуулж зөвлөмж гаргаж хэрэгжүүлэх</p>	<p>Монгол Улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газрын 2015 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн <u>Мэдээлэл хүргүүлэх тухай</u> 748 албан тоотоор ирүүлсний дагуу Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, Авлигын ерөнхий нөхцөл байдлын талаарх мэдээллийг бэлтгэн гаргаж ажиллаж байна. Аймгийн хэмжээнд бүх сум тосгодыг хамран зохион байгуулагддаг уламжлалт “Ээлтэй үйчилгээ–иргэн танд” нэгдсэн арга хэмжээний хүрээнд уг арга хэмжээг аймгийн Засаг даргын Тамгын газраас газар дээр нь зохион байгуулсан ажлын хэсгийн оролцоотойгоор иргэд, олон нийтийн дунд авлигын эсрэг хууль тогтоомж, үйл ажиллагааны төлөвлөгөө, хэрэгжилтээс мэдээлэх, сурталчлах ажлыг зохион байгуулсан. Мөн эрсдэлтэй албан тушаал, ажил үйлчилгээний талаарх судалгааг явуулж нэгдсэн дүн гаргаад байгаа.</p>	100	
34	<p>Тамгын газрын үйл ажиллагаанд Чанарын удирдлагын тогтолцооны Аудитын баг, төсвийн дотоод аудитын хийсэн аудитын дүгнэлт, зөвлөмжийг мэдээлэх, хэрэгжилтэнд дэмжлэг үйлчилгээ зохион байгуулах</p>	<p>Аймгийн Засаг даргын Тамгын газарт Чанарын удирдлагын тогтолцоог ISO 9001:2008 олон улсын стандартыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд уг стандартын хэрэгжилт, аймгийн Засаг даргын Тамгын газрын нэгжүүдийн үндсэн үйл ажиллагаанд чанарын удирдлагын тогтолцооны Аудитын баг 2 удаа аудит хийж, аудитын үр дүнг үндэслэн байнгын сайжруулалтын арга хэмжээ авч илэрсэн зөрчлүүдийг арилган нийт ажилтан, албан хаагчдад мэдээлж ажилласан. Сэлэнгэ аймгийн 2014 оны төсвийн гүйцэтгэлийн тайланд хийгдсэн аудитын дүгнэлт болон 2015 оны хагас жилийн тайлан зэргийг бүрэн эхээр нь аймгийн цахим</p>	100	

		хуудсанд байршуулан олон нийтэд хүргээд байна.		
35	Авлигатай тэмцэх газраас явуулсан Төрийн байгууллагын 2014 оны авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлсэн үнэлгээ дүгнэлтээр илэрсэн зөрчил дутагдлыг залруулах зөвлөмжийг хэрэгжүүлэх ажил зохион байгуулах	Авлигатай тэмцэх газрын даргын 2015 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн <u>“Үнэлгээний дүнгийн тухай” 01/460</u> албан тоотой ирүүлсэн 8 сөрөг арга хэмжээг арилгах ажлын төлөвлөгөө гарган тамгын газрын даргаар батлуулан зохион байгуулж, зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан. Монгол улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газрын 2015 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн <u>Мэдээлэл хүргүүлэх тухай</u> 748 албан тоотой ирүүлсний дагуу Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, Авлигын ерөнхий нөхцөл байдлын талаарх мэдээллийг бэлтгэн гаргаж ажиллаж байна. Мэдээллээ эхний байруудад үнэлүүлсэн аймгуудтай харьцуулан хийсэн.		
36	Иргэд, байгууллагаас авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбогдуулж ирүүлсэн гомдол, мэдээллийг шуурхай хүлээн авах боломж бүрдүүлэх ажиллагаа явуулах	Иргэдийн санал өргөдөл гомдолтой холбогдсон ажил үйлчилгээг Төрийн байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх аргачлал, шалгууруудын дагуу зохион байгуулах хүрээнд аймгийн Засаг даргын Тамгын газарт иргэд олон нийтийн санал хүсэлтийг хүлээн авах <u>7036-1111</u> шууд утас ажиллуулах, энэ ажлыг хариуцсан орон тооны ажилтан ажиллуулах ажиллагаагаа тайлант онд үргэлжлүүлсэн.. Орон нутгийн “Миний монгол” телевизэд <u>“Иргэдээ сонсьё”</u> шууд нэвтрүүлгийг оны эхэнд баталсан хуваариар тогтмол цагт явуулж, тайлант онд 24 байгууллага оролцсон 43 удаагийн нэвтрүүлэг хийгдээд байна. Аймгийн удирдлага, төрийн үйлчилгээний байгууллагууд олон нийтэд мэдээлсэн хуваарийн дагуу уг нэвтрүүлэгт оролцож иргэдийн үгийг сонсож, авсан арга хэмжээгээ хариу мэдээлж байна.	90	
37	Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хянах, хадгалах журмыг мөрдөх, ЭБАТ-дад зориулж ХАСХОМ-ийн бүртгэл, хадгалалт, хамгаалалт, ашиглалттай холбогдсон шинэ болон шинэчлэгдсэн эрх зүйн зохицуулалтуудаар гарын авлага гаргах	Эрх бүхий албан тушаалтнуудад зориулсан албан тушаалтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хянах, хадгалах журмыг мөрдөх, ЭБАТ-ын чиг үүрэг, ХАСХОМ-ийн бүртгэл, хадгалалт, хамгаалалт, ашиглахтай холбоотой шинэчлэгдсэн эрх зүйн зохицуулалтаар гарын авлага гарган ажилласан.	100	
38	Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилтээр Шаамар сумын Засаг даргын сонсголыг Аймгийн Засаг	Төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Шаамар сумын Засаг даргын “Авлигатай тэмцэх, авлигыг үл тэвчих, ёс зүй, шударга ёсыг эрхэмлэх” нь сэдэвт сонсголыг аймгийн Засаг даргын Зөвлөлийн	100	

даргын зөвлөлөөр хэлэлцүүлэх

2015 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 11 дүгээр хуралдаанаар хэлэлцэж сарын аян зохион байгуулах шийдвэр гаргасан. Аймгийн Засаг даргын 2015 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн А/412 тоот захирамжаар сарын аян зохион байгуулж, аяны хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг гарган батлуулан бүх сумдад хүргүүлэн ажиллалаа. Сарын аяны талаарх мэдээллийг цахим хуудас, мэдээллийн самбар, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлсэн. Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн 4 зурагт хуудасны дагуу санамжуудыг бэлтгэн гаргаж төрийн албан хаагчдыг



албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн буюу үүсч болзошгүй тохиолдолд мэдэгдэл, тайлбар гаргах ажил үйлчилгээнд мөрдөж хэвшил болгоод байна.

Тайланг нэгтгэн боловсруулсан:

Хууль зүйн хэлтсийн дарга

Ч.Даваадорж

Авлига, хүний эрхийн асуудал хариуцсан ажилтан
Эрх бүхий албан тушаалтан

Л.Баярсүрэн

Хянасан:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга

Ө.Сувдаа